

**Аймгийн удирдах ажилтнуудын 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн
шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг, даалгавар**

2024.02.02

№	Өгөгдсөн үүрэг, даалгавар	Биелэлт	хувь
1	<p>/Танилцуулга: 2023 оны ХАСХОМ-ийг шинэчлэн гаргах эрхийг https://meduuleg.iaac.mn/ цахим системд 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс нээгээд байна. Авлигын эсрэг хуульд зааснаар мэдүүлэг гаргагч хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргаж өгөх үүрэгтэй боловч мэдүүлэг гаргах үйл явц нь 2024 оны цагаан сарын баярын өдрүүдтэй ойрхон байгаа тул байгууллагынхаа ХАСХОМ гаргах үүрэг бүхий албан тушаалтнуудыг нэгдсэн удирдлагаар ханган 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн дотор мэдүүлгээ гаргаж дуусгахад анхаарч ажиллана уу./</p>	<p>Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг 97 албан тушаалтан гаргахаас 85 албан тушаалтан гаргаж 87.6 хувьтай байна.</p> <p>Гаргаагүй албан тушаалтны тоо: Сүмбэр сумын ЗДТГ- 2 албан тушаалтан Баянтал сумын ЗДТГ- 2 албан тушаалтан Шивээговь сумын ЗДТГ- 2 албан тушаалтан Байгаль орчин, аялал жуулчлалын газар -1 албан тушаалтан Талын илч ОНӨАТҮГ- 1 албан тушаалтан Цөм сүрэг, үржлийн төв- 1 албан тушаалтан Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар- 1 албан тушаалтан Худалдан авах ажилгааны газар- 1 албан тушаалтан</p>	70.0
2	<p>Уламжлалт сар шинийн баяр болохтой холбогдуулан нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулах, аж ахуй нэгж, байгууллагууд хариуцсан нийтийн эдэлбэр газрын 50м хүртэлх талбайн хог хаягдал, цас, мөсийг цэвэрлэж, халтиргаа, гулгаа үүсэхгүй байх тал дээр анхаарч ажиллах.</p>	<p>Бүх нийтийн их цэвэрлэгээг Сүмбэр сум 2024 оны 02 дугаар сарын 02, 03-ны өдөр, Баянтал сум 02 дугаар сарын 02-ны өдрүүдэд тус тус зохион байгуулсан.</p> <p>Сүмбэр суманд 27 төрийн байгууллага, 8 аж ахуй нэгж, 515 өрх, Баянтал сум 6 төрийн байгууллага, 4 аж ахуй нэгж, 11 өрх тус тус 50 метр хүртэлх газрыг цэвэрлэсэн.</p>	70.0
3	<p>Аймаг байгуулагдсаны 30 жилийн ойг угтан нийгмийн хариуцлагын хүрээнд байгууллагууд бүтээн байгуулалтын ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх, төлөвлөгөөгөө ирүүлээгүй байгууллагад НБХ-т яаралтай ирүүлэх.</p>	<p>2024.02.02-ны өдрийн байдлаар 16 байгууллага холбогдох төлөвлөгөөг боловсруулан НБХ-т ирүүлсэн байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Сүмбэр сумын ЗДТГ - Татварын хэлтэс - Эрүүл мэндийн газар - Боржигин өв музей - Насан туршийн боловсролын төв - Ус-Ду ОНӨААТҮГ - Улсын бүртгэлийн хэлтэс - Хүнс, хөдөө, аж ахуйн газар - Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар - Байгаль орчин, аялал жуулчлалын газар - Сум дундын ойн анги - Соёл урлагийн газар - Боловсрол шинжлэх ухааны газар - Шивээговь сумын ЗДТГ - Хүнс, хөдөө аж ахуйн газар - Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар 	30.0

4	Байгууллагууд 2023 онд хийгдсэн томоохон ажлаараа 3-5 минутын видео мэдээлэл бэлтгэн байгууллагынхаа болон аймгийн цахим хуудсанд байршуулж, иргэдэд түгээх.	Видео мэдээлэл бэлтгэн байгууллагын болон аймгийн цахим хуудсаар мэдээлэлсэн 15 байгууллага, 9 байгууллага видео мэдээллийг бэлтгэж байна. Мэдээлэл байршуулсан байгууллагууд: Сүмбэр сумын ЗДТГ Онцгой байдлын газар Байгал орчин, аялал жуулчлалын газар Улсын бүртгэлийн хэлтэс Насан туршийн боловсролын төв Илчлэг шивээ Нийтийн номын сан Боржигин өв музей Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар Эрүүл мэндийн газар Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар Соёл урлагийн газар Сум дундын ой анги Шивээговь сумын ЗДТГ Стандарт хэмжил зүйн газар	70.0
5	Уламжлалт сар шинийн баярыг угтаж өөрийн байгууллагад харьяалалтай ахмад настангуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг танилцуулах.	Төрийн 21 байгууллага 207 ахмад настанд хүндэтгэл үзүүлж, 11 байгууллага хүндэтгэл үзүүлэхээр бэлтгэл ажлыг хангаад байна. Харьяалалгүй ахмад настанг Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газраас хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулж байна.	70.0
Дундаж хэрэгжилт			62.0

Хянасан: ХШҮХ-ийн дарга

М.Анхбаяр

Үүргийн биелэлт нэгтгэж, үнэлсэн:

ХШҮХ-ийн мэргэжилтэн

Б.Мөнхзаяа